



МОНГОЛ ТУТМИН ХЭВЛЭЛ
М 05 дугаар сарын 26
№20 /641/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын
хууль

670

Монгол Улсын
хууль

693

Монгол Улсын
Засгийн газрын
тагтоол

699

**Хөрөнгөөр баталгаажсан үнэт
цаасны тухай**

**Иргэний хуульд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай**

Хөтөлбөр батлах тухай

Улаанбаатар хот
2010 он

Улсын Их Хурлын Тамгын Газар

**ГАРЧИГ****МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

- | | | |
|------|--|-----|
| 155. | Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай | 670 |
| 156. | Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 693 |
| 157. | Компанийн тухай хуульд нэмэлт оруулах тухай | 694 |
| 158. | Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 695 |
| 159. | Дампуурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай | 695 |
| 160. | Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай | 696 |
| 161. | Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт оруулах тухай | 696 |
| 162. | Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай | 697 |
| 163. | Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай | 697 |
| 164. | Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай | 698 |

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- | | | | |
|------|---|-----------|-----|
| 165. | Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай | Дугаар 20 | 698 |
|------|---|-----------|-----|

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- | | | | |
|------|-----------------------|-----------|-----|
| 166. | Хөтөлбөр батлах тухай | Дугаар 60 | 699 |
|------|-----------------------|-----------|-----|



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 04 дүгээр
сарын 23-ны өдөр

Улаанбаатар
хот

ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, түүнд хяналт тавих, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль тогтоомж

2.1.Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Иргэний хууль², Үнэт цаасны зах зээлийн тухай³, Компанийн тухай⁴, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай⁵, энэ хууль болон адгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

2.3.Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагчийг татан буулгахтай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулна.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэхүү хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

¹ Монгол Улсын Үндсэн хууль—“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

² Иргэний хууль—“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

³ Үнэт цаасны зах зээлийн тухай хууль—“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2002 оны 48 дугаарт нийтлэгдсэн.

⁴ Компанийн тухай хууль—“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1999 оны 34 дугаарт нийтлэгдсэн.

⁵ Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль—“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2009 оны 28 дугаарт нийтлэгдсэн.



түрээсийн гэрээ, өрийн бичгээс үүсэх шаардах эрх, зээлийн карт олгогчийн авлага зэрэг мөнгөн урсгал бий болгох боломжтой санхүүгийн хэрэгслийг;

3.1.2. "үүрэг гүйцэтгэгч" гэж гэрээнд заасны дагуу хөрөнгөтэй холбоотой мөнгөн төлбөрийн үүрэг хүлээсэн этгээдийг;

3.1.3. "хөрөнгө оруулагч" гэж хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас өмчлөгч, түүний өв, эсхүл эрх залгамжлагчийг;

3.1.4. "хугацаа хэтэрсэн хөрөнгө" гэж эрх бүхий байгууллагаас тогтоосон журамд заасны дагуу "хугацаа хэтэрсэн" болон "чанаргүй" ангилалд орсон хөрөнгийг;

3.1.5. "худалдагч" гэж анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс хөрөнгө шилжүүлэн авч, тусгай зориулалтын компанид худалдаж байгаа анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс бусад иргэн, хуулийн этгээдийг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААС, ХӨРӨНГИЙН БАГЦ

4 дүгээр зүйл. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, түүний төрөл

4.1. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас нь энэ хуульд заасан хөрөнгөөр баталгааждаг, хөрөнгө оруулагч нь уг хөрөнгийн орлогоос тэргүүн ээлжинд төлбөрөө гаргуулах эрхийг баталгаажуулсан үнэт цаас байна.

4.2. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас нь дараахь төрөлтэй байна:

4.2.1. баталгаат үнэт цаас;

4.2.2. барьцаат үнэт цаас.

4.3. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг түүний хугацаа, хүү, бусад шинжээс нь хамааруулан өрийн бичиг болон Санхүүгийн зохицуулах хороо /цаашид "Хороо" гэх/-ноос зөвшөөрсөн бусад төрлөөр гаргаж болно.

5 дугаар зүйл. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагч

5.1. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг энэ хуулийн 11, 26 дугаар зүйлд заасан этгээд гаргана.

5.2. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг энэ хуулийн 11, 26 дугаар зүйлд зааснаас бусад этгээд гаргахыг хориглоно.



5.3.Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зорилгоор хөрөнгө худалдан авах харилцаа нь факторингийн үйлчилгээнд хамаарахгүй.

5.4.Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах өдөр хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагч /цаашид "үнэт цаас гаргагч" гэх/-тай холбоотой дампуурлын хэрэг үүсгэх хүсэлт, нэхэмжлэл гараагүй, татан буулгах ажиллагаа явагдаагүй, эрх хүлээн авагч томилох тухай эрх бүхий байгууллагын шийдвэр гараагүй байна.

5.5.Энэ хуулийн 5.4-т заасан нөхцөл байдал бий болсон тохиолдолд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахыг хориглоно.

6 дугаар зүйл.Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох

6.1. Үнэт цаас гаргагч нь энэ хуульд заасны дагуу Хорооноос хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авна.

6.2.Хороо энэ хуульд заасан шаардлагыг хангасан үнэт цаас гаргагчид хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгоно.

6.3.Энэ хуулийн 6.2-т заасан тусгай зөвшөөрлийн хугацаа нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны төлбөрийг гүйцэтгэх эцсийн хугацаанаас багагүй байна.

7 дугаар зүйл.Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах

7.1.Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас нь биет болон биет бус хэлбэртэй байна.

7.2.Үнэт цаас гаргагч нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг нийтэд санал болгон нээлттэй, эсхүл нийтэд санал болгохгүйгээр хаалттай гаргаж болно.

7.3.Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг шууд, эсхүл үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаар дамжуулан худалдана.

8 дугаар зүйл. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэх

8.1.Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг энэ хуульд заасны дагуу Хороонд бүртгүүлнэ.



8.2.Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэх журмыг Хороо тогтооно.

8.3.Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг Хороонд бүртгүүлснээр хөрөнгө оруулагчийн энэ хуулийн 4.1-д заасан эрх баталгаажна.

8.4.Үнэт цаас гаргагч нь Хорооноос тогтоосон үнэт цаасны бүртгэлийн хураамж төлнө.

9 дүгээр зүйл. Хөрөнгийн багц, түүнд тавих шаардлага

9.1.Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны нэг удаагийн гаргалтыг баталгаажуулж байгаа хөрөнгийн нийлбэр нь хөрөнгийн багцыг бүрдүүлнэ.

9.2.Хөрөнгийн багцад байгаа хөрөнгө нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үед үнэт цаас гаргагчийн эзэмшилд байх бөгөөд эрхийн доголдолгүй хөрөнгө байна.

9.3.Хөрөнгийн багцад дараахь хөрөнгийг оруулахыг хориглоно:

9.3.1.дуусаагүй барилга, сул чөлөөтэй газрын барьцаа;

9.3.2.зээл болон барьцаа хөрөнгийн үнэлгээний харьцаа нь хуульд заасан эрх бүхий этгээдээс тогтоосон хэмжээнээс хэтэрсэн барьцаат зээл;

9.3.3.хугацаа хэтэрсэн хөрөнгө.

ГУРАВДУГААР БҮЛЭГ БАТАЛГААТ ҮНЭТ ЦААС

10 дугаар зүйл. Баталгаат үнэт цаас

10.1.Баталгаат үнэт цаас нь хөрөнгийг анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үнэт цаас гаргагчийг үүсгэн байгуулагч /цаашид "үүсгэн байгуулагч" гэх/, худалдагчийн санхүүгийн тайлан, тэнцлээс хасч, хөрөнгөтэй холбоотой шаардах эрх болон олох орлогыг тусгай зориулалтын компанийн санхүүгийн тайлан, тэнцэлд шилжүүлэн анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үүсгэн байгуулагч, худалдагчийг хөрөнгөтэй холбоотой үүргээс бүрэн чөлөөлснийг гэрчилсэн үнэт цаас байна.

11 дүгээр зүйл. Баталгаат үнэт цаас гаргагч

11.1.Баталгаат үнэт цаасыг тусгай зориулалтын компани гаргана.



12 дугаар зүйл. Тусгай зориулалтын компани байгуулах

12.1.Тусгай зориулалтын компани нь Компанийн тухай хууль болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай⁶ хуульд заасан журмын дагуу байгуулагдсан, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан тусгай зөвшөөрлийг авсан хязгаарлагдмал хариуцлагатай компани байна.

12.2.Тусгай зориулалтын компани нь хөрөнгийн багцыг өөрийн санхүүгийн тайлан, тэнцэлд шилжүүлэн авах замаар баталгаат үнэт цаасыг хөрөнгө оруулагч эзэмших эрхтэйг баталгаажуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

12.3.Тусгай зориулалтын компанийг баталгаат үнэт цаас гаргах бүрт байгуулна.

12.4.Тусгай зориулалтын компанийг банк, банк бус санхүүгийн байгууллага, орон сууцны санхүүжилтийн компани болон Хорооноос зөвшөөрсөн санхүүгийн бусад байгууллага байгуулж болно.

12.5.Тусгай зориулалтын компанийн нэр нь түүний оноосон нэр болон "тусгай зориулалтын компани" гэсэн дэлгэрэнгүй тэмдэглэгээ, эсхүл "ТЗК" гэсэн товчилсон тэмдэглэгээнээс бүрдэнэ.

12.6.Энэ хуулийн 12.1-д зааснаас өөр этгээд өөрийн оноосон нэртэй хамт "тусгай зориулалтын компани" гэсэн дэлгэрэнгүй тэмдэглэгээ, эсхүл "ТЗК" гэсэн товчилсон тэмдэглэгээ хэрэглэхийг хориглоно.

12.7.Тусгай зориулалтын компанийн хувьцаа эзэмшигч нь Хорооны зөвшөөрөлгүйгээр хувьцаагаа худалдах, арилжих, барьцаалах болон бусад хэлбэрээр шилжүүлэхийг хориглоно.

12.8.Тусгай зориулалтын компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олонхи нь анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үүсгэн байгуулагч, худалдагч, тэдгээрийн хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан болон тэдгээрийн гэр бүлийн гишүүн байхыг хориглоно.

12.9.Тусгай зориулалтын компанийн дүрэмд Компанийн тухай хуульд зааснаас гадна дараахь зүйлийг тусгана:

12.9.1.зөвхөн баталгаат үнэт цаас гаргах зорилготой байх тухай;

12.9.2.баталгаат үнэт цаас бүрэн төлөгдөж дууссан

⁶ Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль—"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2003 оны 22 дугаарт нийтлэгдсэн



тохиолдолд татан буугдах тухай.

12.10.Тусгай зориулалтын компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ, санхүүгийн тайланд тавих шаардлага болон удирдлага, зохион байгуулалтын бүтэц, түүний эрх хэмжээг тогтоосон журмыг Хороо тогтооно.

12.11.Тусгай зориулалтын компани дараахь эрхтэй:

12.11.1. хөрөнгө худалдаж буюу шилжүүлэн авах;

12.11.2. баталгаат үнэт цаас гаргах;

12.11.3. хөрөнгийг өмчлөх, хөрөнгө оруулагчийн эрх ашигт нийцүүлэн хөрөнгийг удирдах;

12.11.4. Хорооноос баталсан журам болон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны танилцуулга /цаашид "үнэт цаасны танилцуулга" гэх/-д заасны дагуу энэ хуулийн 12.11.1-12.11.3-т заасан эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай үйлчилгээ үзүүлэх гэрээ болон бусад гэрээ байгуулах;

12.11.5. баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцын үлдэгдлийн дүн түүний анхны үнийн 20 хувьд хүрсэн тохиолдолд анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үүсгэн байгуулагч, худалдагчтай тохиролцон багцыг буцаан худалдах;

12.11.6. энэ хуульд заасны дагуу үүсмэл гэрээ ашиглах.

12.12.Тусгай зориулалтын компани дараахь үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно:

12.12.1. энэ хуулийн 12.11-д зааснаас өөр үйл ажиллагаа эрхлэх;

12.12.2. энэ хуулийн 12.11-д зааснаас өөр үйл ажиллагаатай холбоотой үүрэг бусдын өмнө хүлээх, өр үүсгэх;

12.12.3. баталгаат үнэт цаасыг худалдсанаас олсон орлогоос эргүүлэн төлөх нөхцөлтэйгээр бусдаас зээл авах;

12.12.4. хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх;

12.12.5. хөдөлмөрийн гэрээ болон бусад гэрээний үндсэн дээр ажилтан авч ажиллуулах;

12.12.6. Хорооны зөвшөөрөлгүйгээр компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах.



12.13.Тусгай зориулалтын компани нь энэ хуулийн 12.11-д заасан эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдсон үйлчилгээг гуравдагч этгээдээр гүйцэтгүүлнэ.

12.14.Тусгай зориулалтын компани нь энэ хуулийн 12.13-т заасан гуравдагч этгээдийн үйлдэл /эс үйлдэхгүй/-ээс үүсэх үүргийг бүрэн хариуцна.

12.15.Тусгай зориулалтын компани нь баталгаат үнэт цаастай холбогдсон үүрэг дуусгавар болмогц татан буугдана.

13 дугаар зүйл.Тусгай зориулалтын компанид хөрөнгө шилжүүлэх

13.1.Анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үүсгэн байгуулагч, худалдагч нь өөрийн хөрөнгийг тусгай зориулалтын компанид гэрээний үндсэн дээр шилжүүлнэ.

13.2.Хөрөнгийг тусгай зориулалтын компанид шилжүүлснээр тухайн хөрөнгөтэй холбоотой аливаа эрх, барьцаа, баталгаа болон үүргийн гүйцэтгэлийг хангах бусад арга, санхүүгийн хэрэгсэл хамт шилжсэнд тооцно.

13.3.Баталгаат үнэт цаасны төлбөрийг бүрэн төлсний дараа үлдсэн хөрөнгө нь тусгай зориулалтын компанийн өмч болно.

13.4.Дараахь тохиолдолд хөрөнгө оруулагч болон тусгай зориулалтын компанитай гэрээ байгуулсан гуравдагч этгээдээс бусад этгээд баталгаат үнэт цаасаар хүлээсэн төлбөрийн үүрэг бүрэн төлөгдөж дуусах хүртэлх хугацаанд тусгай зориулалтын компанийн хөрөнгөтэй холбоотой шаардлага гаргах эрхгүй:

13.4.1.хөрөнгийг зах зээлийн бодит үнээр худалдан авсан;

13.4.2.үүсгэн байгуулагч, худалдагч үйлчилгээ үзүүлэгч нь хөрөнгө оруулагч буюу түүний хууль ёсны төлөөлөгчийн зөвшөөрөлтэйгээр хөрөнгийг, эсхүл хөрөнгөөс олох орлогыг бусдад шилжүүлэх, барьцаалах, арилжих, эргүүлж олж авах, буцаан худалдаж авах, ашиглах зэргээр захиран зарцуулсан;

13.4.3.анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үүсгэн байгуулагч, худалдагч, хөрөнгийг солих нөхцөлгүйгээр худалдсан буюу тусгай зориулалтын компани хөрөнгөтэй холбоотой эрсдэлийг хүлээсэн бол.



14 дүгээр зүйл. Баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцыг бүртгүүлэх

14.1.Баталгаат үнэт цаасны хөрөнгийн багц нь Хороонд хүргүүлсэн үнэт цаасны танилцуулгад хавсаргасан хөрөнгийн жагсаалтаас бүрдэнэ.

14.2.Баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцыг баталгаат үнэт цаасыг гаргахаас өмнө үнэт цаасны танилцуулга, хөрөнгийн жагсаалт, хөрөнгийг тусгай зориулалтын компанид шилжүүлсэн гэрээ болон холбогдох бусад бичиг баримтын хамт Хороонд бичгээр болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

14.3.Хороо баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцыг бүртгэснээр уг багцад орсон хөрөнгийг тусгай зориулалтын компанид шилжсэнд тооцно.

14.4.Хөрөнгө нь үл хөдлөх эд хөрөнгийн барьцаатай бол баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцыг бүртгэсэн тухай Хорооны шийдвэрийг үндэслэн эрхийн улсын бүртгэлийн байгууллага улсын бүртгэлд барьцааны тухай тусгай тэмдэглэл хийнэ.

14.5.Энэ хуулийн 14.4-т заасны дагуу улсын бүртгэлд тэмдэглэл хийхэд тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хөлс авахгүй.

14.6.Үүрэг гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хуульд заасны дагуу дуусгавар болж, тусгай зориулалтын компаниас тусгай тэмдэглэлийг хүчингүй болгох хүсэлт гаргаснаас бусад тохиолдолд энэ хуулийн 14.4-т заасан тусгай тэмдэглэлд зөвхөн Хорооны шийдвэрээр өөрчлөлт оруулна.

14.7.Энэ хуулийн 14.4-т заасан тэмдэглэлийн агуулга, тэмдэглэл хийх журмыг Хороо болон улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

14.8.Энэ хуулийн 14.4-т зааснаас бусад хөрөнгө шилжсэн тухай улсын бүртгэлд бүртгүүлэхийг шаардахгүй.

14.9.Хороо баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцын бүртгэлийг тусад нь хөтлөх бөгөөд уг бүртгэлийн талаар иргэн, хуулийн этгээдэд мэдээлэл өгөх журмыг батална.

15 дугаар зүйл. Баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах

15.1.Баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцад бүртгэгдсэн

хөрөнгийг солих буюу нэмэх замаар уг багцад өөрчлөлт оруулж болно.

15.2.Дараахь тохиолдолд энэ хуулийн 15.1-д заасан хөрөнгийн багцад байгаа хөрөнгийг сольж болно:

15.2.1.хөрөнгө нь шаардлага хангахгүй болсон;

15.2.2.хөрөнгийн хугацаа хэтэрсэн.

15.3.Дараахь тохиолдолд энэ хуулийн 15.1-д заасан хөрөнгийн багцад хөрөнгө нэмж болно:

15.3.1.баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцад байгаа хөрөнгө нь энэ хуулийн 32.1-д заасан шаардлагыг хангахгүй бол;

15.3.2.нээлттэй гаргах нөхцөлийн дагуу нэмэлт үнэт цаас гаргах бол.

15.4.Баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцад өөрчлөлт оруулсан бол энэ хуулийн 14.9-д заасан багцын бүртгэлд өөрчлөлт оруулна.

16 дугаар зүйл. Хөрөнгийг хөрөнгө оруулагчид барьцаалуулах

16.1.Баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцыг энэ хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу бүртгүүлснээр уг багц дахь хөрөнгийг хөрөнгө оруулагчид барьцаалуулсанд тооцно.

16.2.Энэ хуулийн 16.1-д заасан барьцааны эрхэд тусгай зориулалтын компани, түүний зуучлагч, төлөөлөгч, үнэт цаасны хадгаламжийн байгууллага, хөрөнгө итгэмжлэн удирдагчийн эзэмшилд байгаа хөрөнгө буюу аливаа эх үүсвэрээс орох орлого, бүх төрлийн шаардах эрх, хөрөнгө борлуулсны орлого зэрэг бүхий л эрх хамаарна.

16.3.Тусгай зориулалтын компани нь баталгаат үнэт цаас гаргах болон түүнийг бүртгүүлэхтэй холбоотой зардлыг Хорооноос тогтоосон журам болон үнэт цаасны танилцуулгад заасны дагуу хөрөнгөөс олох орлогоос төлж болно.

17 дугаар зүйл. Баталгаат үнэт цаасны харилцаанд оролцогч

17.1.Баталгаат үнэт цаас гаргах үйл ажиллагаанд анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үүсгэн байгуулагч, худалдагч, үйлчилгээ үзүүлэгч, тусгай зориулалтын компани, хөрөнгө итгэмжлэн удирдагч, хөрөнгө оруулагч болон холбогдох бусад этгээд оролцоно.



18 дугаар зүйл. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч

18.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь өөрийн санхүүгийн тайлан, тэнцэлд туссан хөрөнгийг тусгай зориулалтын компанид шилжүүлсэн, эзэлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд байна.

18.2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь баталгаат үнэт цаас гаргах үйл ажиллагаанд дараахь үүрэг хүлээнэ:

18.2.1. солих нөхцөлтэйгээр хөрөнгө шилжүүлсэн бөгөөд хөрөнгө нь шаардлага хангахгүй болсон тохиолдолд тухайн хөрөнгийг буцаан худалдан авах буюу солих баталгаа гаргах;

18.2.2. хөрөнгөтэй холбоотой үйлчилгээг үзүүлэх;

18.2.3. үнэт цаасны танилцуулгад заасан бол хөрөнгийн багцад байгаа хөрөнгийн 20 ба түүнээс дээш хувь нь хугацаа хэтэрсэн хөрөнгөд тооцогдвол тухайн хөрөнгийн багцыг буцаан худалдан авах.

19 дүгээр зүйл. Үйлчилгээ үзүүлэгч

19.1. Үйлчилгээ үзүүлэгч нь үүрэг гүйцэтгэгчтэй харилцаж, хөрөнгөтэй холбоотой төлбөрийг цуглуулан тусгай зориулалтын компанид шилжүүлэх, бүртгэх, тайлагнах болон үйлчилгээ үзүүлэх гэрээнд заасан хөрөнгөтэй холбоотой бусад үйлчилгээ, үйл ажиллагаа эрхлэхээр тусгай зориулалтын компанитай гэрээ байгуулсан хуулийн этгээд байна.

19.2. Үйлчилгээ үзүүлэгч нь үйлчилгээ үзүүлэх гэрээний нөхцөл болон тусгай зориулалтын компани, эсхүл түүний төлөөлөгчөөс түүнд бичгээр өгсөн зааварчилгаанд дурдсан нөхцөлийн дагуу үйл ажиллагаа явуулна.

19.3. Үйлчилгээ үзүүлэгч нь хөрөнгөөс олох орлогыг баталгаат үнэт цаасны хөрөнгийн багц тус бүрээр, багцын тодорхой хэсгээр тусдаа дансанд хуримтлуулна.

19.4. Үйлчилгээ үзүүлэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй бол тусгай зориулалтын компани нь гэрээг цуцалж, шинэ үйлчилгээ үзүүлэгчтэй гэрээ байгуулах эрхтэй.

19.5. Үйлчилгээ үзүүлэх гэрээг цуцалсан тохиолдолд үйлчилгээ үзүүлэгч нь тусгай зориулалтын компанийн сонгож, гэрээ байгуулсан үйлчилгээ үзүүлэгчид дараахь зүйлийг үнэ төлбөргүй шилжүүлнэ:

19.5.1. хөрөнгөтэй холбоотой мөнгөн хөрөнгө;



19.5.2. нягтлан бодох бүртгэлийн баримт, санхүүгийн тайлан зэрэг бүх материалын эх хувийг цахим хувийн хамт.

19.6. Хуульд өөрөөр заагаагүй бол үйлчилгээ үзүүлэгч нь гэрээнд заасан үүргээ энэ хуулийн 19.4-т заасан шинэ үйлчилгээ үзүүлэгчтэй байгуулсан гэрээ хүчин төгөлдөр болох хүртэл хэрэгжүүлнэ.

19.7. Гэрээнд заасан бол үйлчилгээ үзүүлэгчид үйлчилгээний хөлс төлнө.

19.8. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үүсгэн байгуулагч, худалдагч нь үйлчилгээ үзүүлэгчийн үүргийг гүйцэтгэж болно.

19.9. Үйлчилгээ үзүүлэгч нь бусдад санаатай буюу болгоомжгүй үйлдлийн улмаас учруулсан хохирлыг хариуцна.

19.10. Хороо нь үйлчилгээ үзүүлэгчид тавих мэргэшлийн шаардлага, хариуцлага, түүний өөрийн хөрөнгийн доод хэмжээ болон бусад шалгуурыг тогтооно.

20 дугаар зүйл. Хөрөнгө итгэмжлэн удирдагч

20.1. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь тусгай зориулалтын компанитай гэрээ байгуулсан, хөрөнгө оруулагчид барьцаалуулсан хөрөнгийг түүний эрх ашигт нийцүүлэн эзэмшиж, удирдах үүрэг бүхий этгээд байна.

20.2. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь дараахь үүрэг хүлээнэ:

20.2.1. хөрөнгө оруулагчийн эрх ашигт нийцүүлэн хөрөнгийг эзэмших, удирдах;

20.2.2. баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцтай холбоотой санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлийг Хорооноос тогтоосон журамд нийцүүлэн анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үүсгэн байгуулагч, худалдагчийн болон өөрийн хөрөнгийн бүртгэлээс тусад нь хөтлөх;

20.2.3. хөрөнгө оруулагчид шаардлагатай тайлан, мэдээг гаргаж өгөх;

20.2.4. үнэт цаасны төлбөрийг шилжүүлэх;

20.2.5. хөрөнгийг удирдах буюу хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалахад чиглэсэн Хорооноос тогтоосон бусад арга хэмжээг хэрэгжүүлэх.



20.3.Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь хөрөнгө итгэмжлэн удирдагч байхыг хориглоно.

20.4.Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний агуулгыг Хороо тогтоож болно.

20.5.Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний төслийг үнэт цаасны танилцуулгад хавсаргана.

21 дүгээр зүйл. Эрх хүлээн авагч

21.1.Энэ хуулийн 22.1.3-т заасан нөхцөл байдал бий болсон тохиолдолд Хороо эрх хүлээн авагчийг томилно.

21.2.Шаардлагатай гэж үзвэл эрх хүлээн авагчийн үүргийг Хороо гүйцэтгэж болно.

21.3.Эрх хүлээн авагч нь дараахь эрх, үүрэгтэй:

21.3.1.хөрөнгө оруулагчийг хамгаалах зорилгоор хөрөнгийг эзэмшилдээ авах;

21.3.2.тусгай зориулалтын компанийн эрх бүхий албан тушаалтныг өөрчлөх шаардлага гаргах;

21.3.3.үнэт цаасны эргэн төлөлтийг сайжруулах арга хэмжээ авах;

21.3.4.тусгай зориулалтын компанийн байгуулсан үйлчилгээ үзүүлэх гэрээ болон хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд өөрчлөлт оруулах, цуцлах;

21.3.5.Хорооны зөвшөөрлийг үндэслэн үйлчилгээ орон гүйцэтгэгчийг томилох буюу өөр этгээдтэй үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулах;

21.3.6.тусгай зориулалтын компанийг татан буулгах санал гаргах;

21.3.7.Хорооноос зөвшөөрсөн бусад үйл ажиллагаа.

21.4.Эрх хүлээн авагч нь энэ хуулийн 21.3-т заасан эрх, үүргээ Хорооны хяналтын дор хэрэгжүүлнэ.

21.5.Тусгай зориулалтын компанийн эрх бүхий албан тушаалтан, хөрөнгө итгэмжлэн удирдагч нь хөрөнгө болон хөрөнгө оруулагчдын



эрх ашгийг хамгаалахад шаардлагатай бүх арга хэмжээ авч, тусгай зориулалтын компанийн нийт хөрөнгө, санхүүгийн тайлан, тэнцэл, баримт бичиг, албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдгийг эрх хүлээн авагчийн эзэмшилд шилжүүлэх бөгөөд эрх, үүргээ хэрэгжүүлэхэд нь эрх хүлээн авагчтай бүх талаар хамтран ажиллах үүрэгтэй.

22 дугаар зүйл. Тусгай зориулалтын компанийг татан буулгах

22.1.Тусгай зориулалтын компанийг дараахь үндэслэлээр татан буулгана:

22.1.1.баталгаат үнэт цаасаар хүлээсэн үүргээ гүйцэтгэсэн;

22.1.2.баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцыг анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үүсгэн байгуулагч, худалдагч буцаан худалдаж авсан;

22.1.3.баталгаат үнэт цаасны төлбөр төлөх болон үнэт цаасны танилцуулгад заасан үүргээ биелүүлээгүйн улмаас нийт үнэт цаасыг эзэмшиж байгаа хөрөнгө оруулагчдын гуравны хоёроос дээш хувь нь татан буулгахыг шаардсан.

22.2.Тусгай зориулалтын компанийг татан буулгах шийдвэрийг дараахь этгээд гаргана:

22.2.1.энэ хуулийн 22.1.1, 22.1.2-т заасан үндэслэлээр тусгай зориулалтын компани, эсхүл үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлэгч;

22.2.2.энэ хуулийн 22.1.3-т заасан үндэслэлээр Хорооны хүсэлтийг үндэслэн шүүх.

23 дугаар зүйл. Татан буугдсан тусгай зориулалтын компанийн хөрөнгийг хуваарилах

23.1.Татан буугдсан тусгай зориулалтын компанийн хөрөнгийг хуваарилахад дараахь дарааллыг баримтална:

23.1.1.татан буулгах ажиллагааны зардал;

23.1.2.үнэт цаасны танилцуулгад заасан дарааллын дагуу хөрөнгө оруулагчид олгох үнэт цаасны төлбөр;

23.1.3.энэ хуульд заасан гэрээний дагуу тусгай зориулалтын компаниас авлагатай анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс бусад бүх



этгээдийн шаардлага;

23.1.4.энэ хуульд заасан гэрээний дагуу авлагатай анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлага.

23.2.Энэ хуулийн 23.1-д заасны дагуу хөрөнгө хуваарилсны дараа үлдсэн хөрөнгийг оруулсан хөрөнгийн хэмжээтэй нь хувь тэнцүүлэн хувь нийлүүлэгчдэд олгоно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ БАРЬЦААТ ҮНЭТ ЦААС

24 дүгээр зүйл. Барьцаат үнэт цаас

24.1.Барьцаат үнэт цаас нь үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайлан, тэнцэгд тусгаарлан бүртгэгдсэн, орон сууцны зээлийн болон энэ хуулиар зөвшөөрсөн бусад үл хөдлөх эд хөрөнгийн барьцаатай холбоотой шаардах эрхээр баталгаажсан, үнэт цаасны танилцуулгад заасан хугацаанд үндсэн төлбөр, түүний хүүг хөрөнгө оруулагчид төлөх үүргийг гэрчилсэн үнэт цаас байна.

25 дугаар зүйл. Барьцаат үнэт цаасанд тавих шаардлага

25.1.Барьцаат үнэт цаас нь биет болон биет бус хэлбэртэй байх бөгөөд үндсэн төлбөр, хүүг тооцох журмыг агуулсан байна.

25.2.Барьцаат үнэт цаас дараахь нөхцөлтэй байж болно:

25.2.1.тогтмол хугацаатай буюу цуврал;

25.2.2.барьцаат үнэт цаас гаргагч төлбөрийг тогтоосон хугацаанд буюу түүнээс өмнө төлөх;

25.2.3.барьцаат үнэт цаасны үндсэн төлбөрийг хэсэгчлэн төлж дуусгах болон төлбөр төлөх сүүлчийн өдөр төлөх;

25.2.4.тогтмол болон хувьсах хүүтэй байх;

25.2.5.Хорооноос тогтоосон бусад нөхцөл.

26 дугаар зүйл. Барьцаат үнэт цаас гаргагч

26.1.Барьцаат үнэт цаасыг банк, орон сууцны санхүүжилтийн компани тус тус гаргана.

26.2.Барьцаат үнэт цаас гаргагч нь өөрийн эзэмшилд байгаа



санхүүгийн тайлан, тэнцэлд тусгагдсан хөрөнгө болон түүнийг хангах арга, хөрөнгөөс олох орлогыг барьцаалах бөгөөд уг барьцааны хөрөнгийг өөрийн санхүүгийн тайлан, тэнцэлд тусгаарлан уг хөрөнгийн эргэн төлөлтөөр үнэт цаасны төлбөрийг тэргүүн ээлжинд төлнө.

27 дугаар зүйл. Орон сууцны санхүүжилтийн компани

27.1.Орон сууцны санхүүжилтийн компани нь Компанийн тухай хуульд заасан журмын дагуу байгуулагдсан, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан тусгай зөвшөөрөл авсан хязгаарлагдмал хариуцлагатай компани байна.

27.2.Орон сууцны санхүүжилтийн компанийн өөрийн хөрөнгийг мөнгөн хөрөнгөөр бүрдүүлэх бөгөөд өөрийн хөрөнгийн доод хэмжээг Хороо тогтооно.

27.3.Орон сууцны санхүүжилтийн компанийн нэр нь түүний оноосон нэр болон "орон сууцны санхүүжилтийн компани" гэсэн дэлгэрэнгүй тэмдэглэгээ, эсхүл "ОССК" гэсэн товчилсон тэмдэглэгээнээс бүрдэнэ.

27.4.Энэ хуулийн 27.1-д зааснаас өөр этгээд өөрийн оноосон нэртэй хамт "орон сууцны санхүүжилтийн компани" гэсэн дэлгэрэнгүй тэмдэглэгээ, эсхүл "ОССК" гэсэн товчилсон тэмдэглэгээ хэрэглэхийг хориглоно.

27.5.Орон сууцны санхүүжилтийн компанийг 2 ба түүнээс дээш банк хамтран үүсгэн байгуулна.

27.6.Орон сууцны санхүүжилтийн компани нь дор дурдсан үйл ажиллагааг явуулна:

27.6.1.хувь нийлүүлэгч банк болон бусад санхүүгийн байгууллагаас хөрөнгө шилжүүлэн авах, хуримтлуулах;

27.6.2.хөрөнгийн багц бүрдүүлэх;

27.6.3.барьцаат үнэт цаас гаргах;

27.6.4.эргэн төлөлтийг сайжруулах арга хэмжээг авах;

27.6.5.худалдан авах хөрөнгөд тавих шаардлагыг

тогтоох;

27.6.6.энэ хуульд заасны дагуу үүсмэл гэрээ ашиглах;

27.6.7.хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахтай холбоотой бусад үйл ажиллагаа.



27.7.Орон сууцны санхүүжилтийн компани дараахь эрхтэй:

27.7.1.үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй тохиолдолд баталгаат үнэт цаасны тусгайлсан хөрөнгийн багцын бүртгэлд бүртгэгдсэн барьцаа хөрөнгөөс төлбөрөө гаргуулан авах нөхцөлтэйгээр өөрийн хувь нийлүүлэгч банкинд зээл олгох, уг зээлтэй холбоотойгоор энэ хуульд заасан хөрөнгө оруулагчийн бүхий л эрхийг эдлэх;

27.7.2.өөрийн хувь нийлүүлэгч банкинд олгосон зээлийн барьцаа хөрөнгийг хөрөнгө оруулагчид барьцаалах замаар барьцаат үнэт цаас гаргах.

27.8.Орон сууцны санхүүжилтийн компани нь өөрийн хувь нийлүүлэгч банкинд олгосон зээлтэй холбоотой шаардах эрхээ гэрээгээр баталгаажуулах бөгөөд уг эрх нь хөрөнгийн багцын бүртгэлд орно.

28 дугаар зүйл. Барьцаат үнэт цаасны хөрөнгийн багц

28.1.Барьцаат үнэт цаасны хөрөнгийн багц үндсэн болон нэмэлт хөрөнгөөс бүрдэнэ.

29 дүгээр зүйл. Үндсэн хөрөнгө

29.1.Барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцад байгаа үндсэн хөрөнгөд орон сууцны зээл болон барьцаанаас үүссэн шаардах эрх хамаарна.

29.2.Хороо зөвшөөрсөн бол үл хөдлөх эд хөрөнгө авах зориулалтаар олгосон санхүүгийн түрээс, зээлээр худалдах, худалдан авах гэрээ буюу тэдгээртэй төсөөтэй орлого бий болгох хөрөнгийг үндсэн хөрөнгөд оруулж болно.

29.3.Барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцыг бүрдүүлж байгаа үл хөдлөх эд хөрөнгө барьцаалсан зээл нь улсын бүртгэлд бүртгэгдсэн, анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн тэргүүн ээлжинд шаардлагаа хангуулах давуу эрхийг баталгаажуулсан байна.

29.4.Барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцад бүртгэгдсэн хөрөнгийн 10 хүртэл хувь нь орон сууцны бус зориулалт бүхий үл хөдлөх эд хөрөнгө олж авахад зориулан олгосон зээл байж болно.

30 дугаар зүйл. Нэмэлт хөрөнгө

30.1.Дараахь зүйл хөрөнгийн багц дахь нэмэлт хөрөнгө байж

болно:

30.1.1.бэлэн мөнгө;

30.1.2.Монгол Улсын Засгийн газар болон Монголбанкнаас гаргасан үнэт цаас;

30.1.3.энэ хуулийн 27.7.1-д заасан журмын дагуу олгосон зээл.

30.2.Нэмэлт хөрөнгө нь барьцаат үнэт цаасыг баталгаажуулж байгаа багцын дүнгийн 20 хувиас хэтрэхгүй байна.

30.3.Нэмэлт хөрөнгийн үнийг тооцох журмыг Хороо тогтооно.

31 дүгээр зүйл. Барьцаалуулсан үл хөдлөх эд хөрөнгийг үнэлэх

31.1.Барьцаалуулсан үл хөдлөх эд хөрөнгийг холбогдох хуульд заасны дагуу үнэлүүж болно.

31.2.Хороо энэ хуулийн 31.1-д заасан үнэлгээтэй холбогдсон нарийвчилсан журам гаргаж болно.

32 дугаар зүйл. Барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцад тавих шаардлага

32.1.Барьцаат үнэт цаасны хөрөнгийн багц нь дарвахь шаардлагыг хангасан байна.

32.1.1.барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцаас орох орлого нь барьцаат үнэт цаасны дагуу хүлээсэн үүргийг гүйцэтгэхэд хүрэлцэхүйц байх;

32.1.2.барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцад байгаа хөрөнгийн үнийн дүнгийн нийлбэр нь үнэт цаасны төлбөрийн төлөгдөөгүй үнийн дүнгийн нийлбэрийн 110 хувиас багагүй байх;

32.1.3.барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцад байгаа хөрөнгийн дундаж хүү үнэт цаасны хүүтэй тэнцүү буюу түүнээс их байх;

32.1.4.барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцад байгаа хөрөнгийн дундаж хугацаа үнэт цаасны дундаж хугацаанаас багагүй байх.

32.2.Хөрөнгийн багцад тавих нарийвчилсан шаардлагыг Хороо тогтооно.



33 дугаар зүйл. Барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцын бүртгэл

33.1.Барьцаат үнэт цаас гаргагч нь тухайн үнэт цаасыг баталгаажуулж байгаа хөрөнгийн багцын бүртгэл хөтөлнө.

33.2.Барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцын бүртгэлийг тухайн үнэт цаас гаргагчийн гаргасан бүх үнэт цаасны хувьд нэгтгэн, эсхүл гаргасан үнэт цаас тус бүрээр хөтөлж болно.

33.3.Барьцаат үнэт цаас гаргагч нь банк бол барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцын бүртгэлийг Хороо болон Монголбанкнд, орон сууцны санхүүжилтын компани бол Хороонд хүргүүлнэ.

33.4.Барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцын бүртгэлийн маягт, түүнийг хөтлөх журмыг Хороо тогтооно.

33.5.Хороо энэ хуулийн дагуу барьцаат үнэт цаасыг бүртгэснээр хөрөнгийн багцыг үнэт цаас гаргагчийн хөрөнгөөс тусгаарлаж, барьцаалсан гэж үзнэ.

33.6.Барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцад байгаа хөрөнгийн талаар эрхийн улсын бүртгэлийн байгууллага нэмэлт тэмдэглэл хийхэд энэ хуулийн 14.5-14.7-д заасан журам нэгэн адил хамаарна.

34 дүгээр зүйл. Барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах

34.1.Барьцаат үнэт цаас гаргагч нь үнэт цаас нэмж гаргах буюу хөрөнгийн багцыг энэ хуулийн 32 дугаар зүйлд заасан шаардлагад нийцүүлэх зорилгоор хөрөнгийн багц дахь үндсэн хөрөнгийг хэдийд ч нэмэгдүүлж болно.

34.2.Барьцаат үнэт цаас гаргагч нь энэ хуулийн 36.4.3-т заасан хөрөнгийн багцын бүртгэлийг хянагчийн зөвшөөрлийг үндэслэн хөрөнгийн багцад байгаа хөрөнгийг хэдийд ч сольж болно.

35 дугаар зүйл. Барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцыг тусгаарлах, барьцаалах

35.1.Барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцыг бүртгэснээр түүнийг бүрдүүлж байгаа хөрөнгийг барьцаат үнэт цаас гаргагчийн бусад хөрөнгөнөөс тусгаарласанд тооцох бөгөөд уг хөрөнгийг үнэт цаас гаргагч нь санхүүгийн тайлан, тэнцэлдээ тусад нь хөтөлнө.



35.2.Барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцад байгаа хөрөнгийг энэ хуульд зааснаас бусад зориулалтаар ашиглахыг хориглоно.

35.3.Хөрөнгө оруулагч нь барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцаас үнэт цаастай холбоотой шаардах эрхээ тэргүүн ээлжэнд хангуулах эрхтэй байна.

35.4.Хэд хэдэн хөрөнгө оруулагчийн шаардах эрх ижил хөрөнгийн багцаар баталгаажсан бол шаардах эрхээ уг эрх үүссэн хугацааны дарааллын дагуу, оруулсан хөрөнгийн хэмжээтэй хувь тэнцүүлэн хангуулна.

35.5.Барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцад хамаарах үүсмэл гэрээний талууд нь тухайн багцын хувьд гэрээ байгуулах, цуцлах, эрхээсээ татгалзах, хөрөнгө оруулагчийн эрхийн хүрээнд үнэт цаас гаргагчийн эсрэг нэхэмжлэл гаргах эрхтэй.

35.6.Барьцаат үнэт цаасны төлбөрийг хөрөнгийн багцад байгаа хөрөнгөөр бүрэн хангана.

35.7.Тус тусдаа бүртгэлтэй барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцаар баталгаажсан үнэт цаасны хөрөнгө оруулагчид тухайн барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцаар нэхэмжлэлээ хангуулсны дараа барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцад ороогүй үнэт цаас гаргагчийн бусад хөрөнгөөс үлдэгдэл төлбөрөө гаргуулахад бусад хөрөнгө оруулагчтай тэгш эрхтэй байна.

35.8.Үнэт цаас гаргагч дампуурсан, эсхүл үүргээ биелүүлэх боломжгүй болсноос бусад тохиолдолд барьцаат үнэт цаасны хөрөнгийн багц буюу тухайн үнэт цаас гаргагчийн хүлээх үүргийг Хорооноос тогтоосон журамд нийцүүлэн үнэт цаасны танилцуулгад заасан нөхцөлөөр бусдад бүхэлд нь шилжүүлж болно.

36 дугаар зүйл. Барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцын бүртгэлийг хянагч

36.1.Барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцын бүртгэлийг хянагч /цаашид "хөрөнгийн багцын бүртгэлийг хянагч" гэх/ нь барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцын бүртгэл хөтөлөлд хяналт тавих, хөрөнгийн багцын хэвийн байдлыг хангах, энэ хуулийн 32 дугаар зүйлд заасан шаардлагад нийцэж байгаа эсэхэд хяналт тавих чиг үүрэг бүхий этгээд байна.

36.2.Хөрөнгийн багцын бүртгэлийг хянагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Хороо олгох бөгөөд түүнд тавих мэргэшлийн шаардлага, зөвшөөрөл олгох, томилох, чөлөөлөх журмыг Хороо тогтооно.



36.3.Хөрөнгийн багцын бүртгэлийг хянагчийг барьцаат үнэт цаас гаргагч томилж бөгөөд энэ тухайгаа ажлын 3 өдрийн дотор Хороонд бичгээр мэдэгдэнэ.

36.4.Хөрөнгийн багцын бүртгэлийг хянагч нь дараахь үүрэгтэй:

36.4.1.хөрөнгийн багц энэ хууль болон Хорооноос тогтоосон журамд заасан шаардлагад нийцэж байгаа эсэхэд хяналт тавих;

36.4.2.хөрөнгийн багцад байгаа хөрөнгийг солих болон хөрөнгийн багцтай холбоотой гүйлгээнд хяналт тавих;

36.4.3.хөрөнгийн багцаас зарлагын гүйлгээ хийх зөвшөөрөл олгох;

36.4.4.хөрөнгийн багцын бүртгэлд орсон өөрчлөлтийг баталгаажуулж энэ талаар 15 хоногийн дотор Хороо болон Монголбанкинд мэдэгдэх;

36.4.5.Хорооноос тогтоосон хугацаанд хөрөнгийн багцын бүртгэлд төлөвлөгөөт шалгалт хийх;

36.4.6.энэ хуулийн 36.4.5-д заасан төлөвлөгөөт шалгалтыг хийснээс хойш 15 хоногийн дотор тухайн бүртгэлийн үйл ажиллагаанд илэрсэн аливаа зөрчил, түүнийг арилгах талаар өгсөн зөвлөмжийн тухай тайланг барьцаат үнэт цаас гаргагч, Хороо болон Монголбанкинд хүргүүлэх;

36.4.7.хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалахад шаардлагатай бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

36.5.Хөрөнгийн багцын бүртгэлийг хянагч нь барьцаат үнэт цаас гаргагч болон эрхийн улсын бүртгэлийн байгууллагаас тухайн үнэт цаасыг баталгаажуулж байгаа хөрөнгийн багцтай холбоотой аливаа мэдээллийг авах, холбогдох баримт бичигтэй танилцах эрхтэй.

37 дугаар зүйл. Онцгой нөхцөл байдал үүсэх

37.1.Дараахь тохиолдолд онцгой нөхцөл байдал үүссэн гэж үзнэ:

37.1.1.барьцаат үнэт цаас гаргагчтай холбоотой дампуурлын хэрэг үүссэн;

37.1.2.барьцаат үнэт цаас гаргагчийг татан буулгаж



болзошгүй болсон;

37.1.3.барьцаат үнэт цаас гаргагчийг хуульд заасан үндэслэлээр эрх бүхий байгууллага өөрчлөн байгуулахаар шийдвэрлэсэн.

37.2.Хороо энэ хуулийн 37.1-д заасан онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд дараахь арга хэмжээг нэн даруй авна:

37.2.1.барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцыг хөрөнгө оруулагчийн шаардлагыг бүрэн хангах хүртэл барьцаат үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайлан, тэнцлээс тусгаарлах;

37.2.2.телберийн чадваргүй болсон барьцаат үнэт цаас гаргагч нь банк бол Монголбанкттай хамтран, орон сууцны санхүүжилтийн компани бол дангаараа эрх хүлээн авагчийг томилох.

37.3.Хөрөнгийн багцын бүртгэлийг хянагч нь онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд эрх хүлээн авагч томилогдох хүртэлх хугацаанд дараахь үүрэг хүлээнэ:

37.3.1.барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцыг эзэмшилдээ авах;

37.3.2.барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцаас орох орлогыг төвлөрүүлэх.

37.4.Хөрөнгийн багцын бүртгэлийг хянагч нь үнэт цаасыг баталгаажуулж байгаа багцыг хамгаалахад шаардлагатай холбогдох бүх данс, баримт, материалын эхийг эрх хүлээн авагчид хүргүүлэх үүрэгтэй.

37.5.Эрх хүлээн авагч нь өөрийг нь томилсон эрх бүхий этгээдэд дараахь саналын аль нэгийг хүргүүлнэ:

37.5.1.барьцаат үнэт цаасны телберийг хугацаанаас нь өмнө төлүүлэхээр барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцад байгаа хөрөнгийг худалдан борлуулах;

37.5.2.барьцаат үнэт цаасны хугацааг өөрчлөлгүйгээр үнэт цаасаар хүлээсэн үүрэг болон барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцыг өөр үнэт цаас гаргагчид шилжүүлэх;

37.5.3.энэ хуулийн 37.5.2-т заасан аргыг хэрэглэх боломжгүй гэж үзвэл барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцыг хөрөнгө итгэмжлэн удирдагчийн удирдлагад шилжүүлэх;



37.5.4.барьцаат үнэт цаасны эргэн төлөлтийг сайжруулах арга хэмжээ авах.

37.6.Энэ хуулийн 37.5-д заасны дагуу эрх хүлээн авагчийн гаргасан саналыг үндэслэн түүнийг томилсон эрх бүхий этгээд шийдвэр гаргана.

37.7.Эрх хүлээн авагч нь үйлчилгээнийхээ хөлсийг барьцаат үнэт цаасыг баталгаажуулж байгаа хөрөнгийн багцаас олох орлогоос хөрөнгө оруулагчаас тэргүүн ээлжинд авах эрхтэй бөгөөд уг хөлсний хэмжээг банк, санхүүгийн салбарт тогтсон жишигт нийцүүлэн Хороо буюу Монголбанк тогтооно.

37.8.Энэ зүйлд заасныг хэрэгжүүлэхтэй холбогдсон тусгай журмыг Хороо болон Монголбанк хамтран батална.

37.9.Барьцаат үнэт цаас гаргагч төлбөрийн чадваргүй болсон нь өөрийн үнэт цаасны төлбөрийг хугацаанаас нь өмнө төлөхийг шаардах эрхийг хөрөнгө оруулагчид олгох үндэслэл болохгүй.

ТАВДУГААР БҮЛЭГ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ

38 дугаар зүйл. Хөрөнгө оруулагчийн шаардлагыг хангах

38.1.Хөрөнгө оруулагчийн шаардлагыг хөрөнгөтэй холбоотой бүх эрхээр хангана.

39 дүгээр зүйл. Хөрөнгө оруулагчид тайлагнах

39.1.Үнэт цаас гаргагч нь хагас жил тутам үнэт цаасны ангилал тус бүрээр тайлан гаргаж хөрөнгө оруулагч болон Хороонд хүргүүлнэ.

39.2.Энэ хуулийн 39.1-д заасан тайланд дараахь мэдээллийг тусгана:

39.2.1.хөрөнгийн багцын үлдэгдэл;

39.2.2.хугацаандаа болон хугацаа хэтэрч төлөгдсөн үндсэн төлбөрийн хэмжээ;

39.2.3.хугацаанаасаа өмнө төлөгдсөн үндсэн төлбөрийн хэмжээ;

39.2.4.ердийн шаардлагад нийцэхгүй болсон буюу

хугацаа хэтэрсэн хөрөнгийн хэмжээ;

39.2.5.хөрөнгө болон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны санхүүгийн нөхцөлд нөлөөлөхүйц бусад мэдээлэл.

39.3.Энэ хуулийн 39.1-д заасан тайлангийн хэлбэр, тайланд тусгах нэмэлт мэдээллийн агуулгыг Хороо тогтооно.

40 дүгээр зүйл. Хөндлөнгийн аудит

40.1.Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд Хорооноос эрх авсан хөндлөнгийн аудитор аудит хийнэ.

40.2.Энэ хуулийн 40.1-д заасан аудит хийх хэлбэр, давтамж, аудиторт тавих мэргэшлийн шаардлага, түүнд хүлээлгэх хариуцлага, аудит хийх эрх олгох журмыг Хороо тогтооно.

41 дүгээр зүйл. Эргэн төлөлтийг сайжруулах арга хэмжээ

41.1.Үнэт цаас гаргагч нь шаардлагатай гэж үзвэл үнэт цаасны эргэн төлөлтийг сайжруулах арга хэмжээг авна.

42 дугаар зүйл. Баталгаа гаргах

42.1.Анхны үүрэг гүйцэтгүүлэгч, орон сууцны санхүүжилтийн компани, Засгийн газар, Монголбанк болон бусад гуравдагч этгээд барьцаат үнэт цаасанд баталгаа гаргаж болно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

43 дугаар зүйл. Монголбанкны оролцоо

43.1.Банкны үйл ажиллагааг хянах, зохицуулах талаар банкны тухай хууль тогтоомжид заасан Монголбанкны бүрэн эрх энэ хуульд заасан анхны үүрэг гүйцэтгүүлэгч буюу хөрөнгө итгэмжлэн удирдагчийн чиг үүргийг хэрэгжүүлж байгаа банкинд нэгэн адил хамаарна.

43.2.Барьцаат үнэт цаас гаргахтай холбоотойгоор банкны үйл ажиллагааг зохицуулах эрхийг энэ хуулиар Хороонд олгосон нь банкны үйл ажиллагааг зохицуулах талаар Монголбанкны бүрэн эрхийг өөрчлөх буюу хязгаарлахгүй.



44 дүгээр зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

44.1.Хорооны улсын байцаагч хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол дор дурдсан захиргааны шийтгэл ногдуулна:

44.1.1.энэ хуулийн 7.1, 12.4-12.6, 12.12.5, 21.5, 27.3, 27.4, 34.2, 39.1-д заасныг зөрчсөн хуулийн этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 40 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 4 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

44.1.2.энэ хуулийн 5.4, 12.12.1-12.12.4, 33.3, 36.3, 36.4, 37.4-т заасныг зөрчсөн хуулийн этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох.

44.2.Энэ хуульд заасан захиргааны шийтгэл ногдуулсан нь гэм буруутай этгээдийг хөрөнгө оруулагчид учруулсан хохирлоо төлөх үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

45 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

45.1.Энэ хуулийг 2011 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 04 дүгээр
сарын 23-ны өдөр

Улаанбаатар
хот

ИРГЭНИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Иргэний хуульд дор дурдсан агуулгатай дараахь хэсэг нэмсүгэй:

1/32 дугаар зүйлийн 32.12 дахь хэсэг:



"32.12.Хуульд өөрөөр заагаагүй бол хуулийн этгээдийг татан буулгахад энэ зүйлийг баримтална."

2/235 дугаар зүйлийн 235.6 дахь хэсэг:

"235.6.Үүрэг хүлээгчийн үүргийн гүйцэтгэлийг хангуулах зорилгоор эд хөрөнгийн өмчлөх эрхийг фидуцийн үндсэн дээр гуравдагч этгээдэд шилжүүлсэн бол гуравдагч этгээд нь энэ хуулийн 37 дугаар бүлэгт заасан хөрөнгө итгэмжлэх гэрээний журмаар уг эд хөрөнгийг үүрэг хүлээгчийн эрх ашгийн үүднээс өмчилж, удирдана."

2 дугаар зүйл.Иргэний хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсгийн "Хуулийн этгээдийг" гэснийг "Хуульд өөрөөр заагаагүй бол хуулийн этгээдийг" гэж, мөн зүйлийн 32.5 дахь хэсгийн "Татан буутгаж байгаа" гэснийг "Хуульд өөрөөр заагаагүй бол татан буутгаж байгаа" гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 04 дүгээр
сарын 23-ны өдөр

Улаанбаатар
хот

**КОМПАНИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Компанийн тухай хуулийн 42 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 42.6 дахь хэсэг нэмсүгэй:

"42.6.Энэ зүйлд заасан журам хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахтай холбогдсон харилцаанд хамаарахгүй."

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**2010 оны 04 дүгээр
сарын 23-ны өдөрУлаанбаатар
хот**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд дор дурдсан агуулгатай дараахь заалт нэмсүгэй:

1/3 дугаар зүйлийн 3.1.6 дахь заалт:

"3.1.6.хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа;"

2/6 дугаар зүйлийн 6.2.6 дахь заалт:

"6.2.6.хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны чиглэлээр Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасан."

2 дугаар зүйл. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6 дахь заалтын дугаарыг "3.1.7" болгон өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА****Д.ДЭМБЭРЭЛ****МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**2010 оны 04 дүгээр
сарын 23-ны өдөрУлаанбаатар
хот**ДАМПУУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Дампуурлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтын "гэж" гэсний дараа "тусгай зориулалтын компани, орон сууцны санхүүжилтийн компаниас бусад" гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА****Д.ДЭМБЭРЭЛ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 04 дүгээр
сарын 23-ны өдөр

Улаанбаатар
хот

АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 15.3.6-15.3.8 дахь заалт нэмсүгэй:

*15.3.6.хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах;

15.3.7.барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцын бүртгэлийг хянагчийн үйл ажиллагаа эрхлэх;

15.3.8.хөрөнгөөр баталгаажсан үнэт цаастай холбоотойгоор хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэх.*

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 04 дүгээр
сарын 23-ны өдөр

Улаанбаатар
хот

БАНК, ЭРХ БҮХИЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН МӨНГӨН ХАДГАЛАМЖ, ТӨЛБӨР ТООЦОО, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт дор дурдсан агуулгатай 9, 10 дахь заалт нэмсүгэй:

*9/гуравдагч этгээдийн өмнө зээлдэгчийн хүлээсэн мөнгөн төлбөрийн үүрэгтэй холбогдсон мэдээлэл;

10/зээлдэгчийн орлогын талаархи мэдээлэл.*



2 дугаар зүйл. Энэ хуулийг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 04 дүгээр
сарын 23-ны өдөр

Улаанбаатар
хот

**ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтын "сангийн хувьцаа," гэсний дараа "хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас," гэж, мөн зүйлийн 3.1.6 дахь заалтын "хугацааны" гэсний дараа "туршид болон" гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 04 дүгээр
сарын 23-ны өдөр

Улаанбаатар
хот

**АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН
АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 12 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 12.1.34 дэх заалт нэмсүгэй:

"12.1.34.тусгай зориулалтын компани болон орон сууцны санхүүжилтийн компаниас хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас эзэмшигчид шилжүүлсэн үнэт цаасны төлбөр болон хүүгийн төлбөр."

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 04 дүгээр
сарын 23-ны өдөр

Улаанбаатар
хот

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 13.1.17 дахь заалт нэмсүгэй:

"13.1.17.банк, банк бус санхүүгийн байгууллага болон бусад хуулийн этгээдээс банк, тусгай зориулалтын компани, орон сууцны санхүүжилтийн компанид хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зориулалтаар шилжүүлсэн зээл, санхүүгийн түрээсийн гэрээнээс үүсэх болон бусад шаардах эрх."

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2010 оны 04 дүгээр
сарын 23-ний өдөр

Дугаар 20

Улаанбаатар
хот

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль баталсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Зэрэглэл тогтоох болон хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг бий болгох зорилгоор холбогдох хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, 2010 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх арга

хэмжээ авахыг Засгийн газар /С.Батболд/-т даалгасугай.

2.Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаастай холбоотойгоор зэрэглэл тогтоох үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдсон түр журам тогтоон мөрдүүлэхийг Санхүүгийн зохицуулах хороо /Д.Баярсайхан/-нд даалгасугай.

3.Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасан журмуудыг баталж 2011 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдүүлэхийг Монголбанк /Л.Пүрэвдорж/, Санхүүгийн зохицуулах хороо /Д.Баярсайхан/-нд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 3 дугаар
сарын 10-ны өдөр

Дугаар 60

Улаанбаатар
хот

Хөтөлбөр батлах тухай

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Чацаргана" хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.
2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, Сангийн сайд С.Баярцогт, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгах нь:

а) хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг жил бүрийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх Үндсэн чиглэл болон шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт тусгаж санхүүжүүлэн хэрэгжүүлэх арга хэмжээг авсугай,

б) хөтөлбөрийн зарим арга хэмжээг олон улсын байгууллагын зээл, тусламж, гадаад оронтой тогтоосон хоёр болон олон талт хамтын ажиллагааны төсөл, арга хэмжээнд хамруулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсугай.

3. "Чацаргана" хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг зохион байгуулж, түүний явц, үр

дүнг жил бүрийн I улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунайд үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН
ҮЙЛДВЭРИЙН САЙД**

Т.БАДАМЖУНАЙ

Засгийн газрын 2010 оны 60 дугаар
тогтоолын хавсралт

“ЧАЦАРГАНА” ХӨТӨЛБӨР

**Нэг. Жимс, жимсгэний хэрэглээ, үйлдвэрлэлийн
өнөөгийн байдал**

1. Жимс, жимсгэнэ нь хүний биед зайлшгүй хэрэгцээт амин дэм, сахар, эрдсийн элемент болон биологийн идэвхт бодисоор баялаг хүнсний чухал бүтээгдэхүүн төдийгүй бут сөөг нь ойн зурвас, ногоон байгууламж байгуулах замаар хөрс хамгаалах, уур амьсгалыг зөөлрүүлэх, элсний нүүдлийг зогсооход хамгаалалт болдог олон талын ашиг тустай. Манай оронд байгаль, цаг уурын нөхцөлд зохицсон 60 гаруй зүйлийн зэрлэг жимс, жимсгэнэ ургадаг.

2. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын тооцоогоор насанд хүрсэн хүн жилд дунджаар 87.6 кг, өдөрт 240 гр жимс, жимсгэнэ хэрэглэх нь зохистой гэж үздэг. Манай улсын нэг хүн 1990 онд 12 кг жимс, жимсгэнэ хэрэглэж байсан бол 2007 онд 8.4 кг болж буурсны зэрэгцээ чанарын баталгаагүй импортын жимс хэрэглэж байна. Сүүлийн жилүүдэд жимс, жимсгэний хэрэгцээ огцом өсч, байгалийн жимсийг олон хэлбэрээр ашиглаж байгаа ч, нөөцийг нь арвижуулах асуудал хоцорч байна. 2009 оны байдлаар улсын хэмжээнд 1200 га талбайд жимс, жимсгэнэ тариалж байгаагийн 80 гаруй хувийг чацаргана эзэлж байна. Чацаргана нь найрлагадаа С, В1, В2, В9, А, К, F, В, Р бүлгийн амин дэм, тос, биологийн идэвхт бодис агуулан хүнсний болон гоо сайхан, эмийн олон нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үнэт түүхий эд тул түүний эрэлт хэрэгцээ дотоодод ч, дэлхийн зах зээл дээр ч жилээс жилд өсөн нэмэгдэж байна. Манай орны эрдэмтэн судлаач, аж ахуй эрхлэгчид өөрийн орны болон ОХУ-ын 10 гаруй сортын чацарганыг

нутагшуулан үржүүлэх, тариалах агротехникийг бий болгож, шинэ сорт гаргах, жимс хураах, үйлдвэрлэлийн аргаар боловсруулах технологитой болсон байна.

Хоёр. Хөтөлбөр боловсруулах шаардлага, үндэслэл

3. Нэг га талбайд 1200-1600 чацарганы суулгац суулгаж нэг бутнаас 7-10 кг жимс хурааж, 1 тонн жимснээс 20-50 кг тос, 600 л цэвэр шүүс, бусад төрлийн бүтээгдэхүүн гарган авах бодит бололцоотой бөгөөд нийт зарцуулсан хөрөнгийг 2-3 жилд нөхөж ашигтай ажиллах тооцоог эрдэмтэд гаргасан байна. Жимс, жимсгэнэ, түүний дотроос чацаргана тариалах хөдөлгөөнийг дэмжих, түүнийг хүмүүсийн амьдрал ахуйгаа дээшлүүлэх, ажлын байр бий болгохын зэрэгцээ боловсруулах үйлдвэр байгуулан бүтээгдэхүүн үйлдвэрлэж дотооддоо хэрэглэх, гадаад зах зээлд нийлүүлэх тодорхой бодлоготой ажиллах зайлшгүй шаардлага гарч байна. Сүүлийн 40-өөд жилийн туршлагаас үзэхэд чацарганыг манай орны аль ч бүсэд тариалах бололцоотой байна.

4. Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Чацаргана” хөтөлбөрийг хэрэгжүүлэх, энэ хөтөлбөрийн хүрээнд эхний ээлжинд 20 мянган га хүртэл талбайд чацаргана тариалж, түүнийг боловсруулах үйлдвэр байгуулна” гэж заасныг үндэслэн энэхүү хөтөлбөрийг боловсруулав.

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим

5. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ ногоон эдийн засгийн үзэл баримтлалд тулгуурлан дараахь зарчмыг баримтална:

5.1. Гарал үүсэл нь тодорхой бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтын аль ч дамжлагад стандарт, эрүүл ахуйн шаардлагыг чанд баримтлах;

5.2. Экспортын баримжаатай экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэн тэргүүнд дэмжих;

5.3. Байгаль экологийн тэнцвэрт байдлыг хадгалан техник,



технологийн дэвшил, шинжлэх ухааны ололтыг ашиглах;

5.4. Төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын харилцан ойлголцол, иж бүрэн түншлэлийг чухалчлах.

Дөрөв. Хөтөлбөрийн зорилго, зорилт

6. Хөтөлбөрийн зорилго нь чацарганыг аж ахуйн болон өрхийн тариалангийн чиглэлээр 20 мянган га хүртэл талбайд тариалж цөлжилтөөс сэргийлэх, хөрс, байгаль орчныг хамгаалах, хүн амыг амин дэм бүхий жимс, жимсгэнээр тогтвортой хангахад оршино.

7. Хөтөлбөрийн зорилгын хүрээнд дараахь зорилтыг хэрэгжүүлнэ:

7.1. Чацаргана, бусад төрлийн жимс, жимсгэний аж ахуй эрхлэх, хөгжүүлэх эрх зүй, адийн засгийн таатай орчинг бүрдүүлэх;

7.2. Чацаргана, бусад төрлийн жимс, жимсгэнэ тариалах, хураан авах, боловсруулах технологийг боловсронгуй болгох, мэргэжилтний чадавхийг сайжруулах;

7.3. Чацаргана тариалах, боловсруулах үйлдвэр байгуулах, хөгжүүлэх санаачилгыг технологийн удирдлага, санхүү, хөрөнгө оруулалт, зээлийн бодлогоор дэмжих замаар бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх;

7.4. Бусад төрлийн жимс, жимсгэнэ тариалахыг дэмжих замаар жимс, жимсгэний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн зах зээлд өрсөлдөх чадварыг хөгжүүлж, импортыг бууруулах;

7.5. Хөтөлбөрийн ач холбогдлыг нийтэд сурталчлах, жимс, жимсгэнэ, түүгээр боловсруулсан бүтээгдэхүүний борлуулалтын сүлжээ бий болгох.

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

8. Чацаргана, бусад төрлийн жимс, жимсгэний аж ахуй эрхлэх,



хөгжүүлэх эрх зүй, эдийн засгийн таатай орчинг бүрдүүлэх” зорилтын хүрээнд:

8.1. Чацаргана, жимс, жимсгэнэ тариалж байгаа болон түүний үр жимс, түүхий эдийг боловсруулах чиглэлээр үйлдвэрлэл, үйл ажиллагаа явуулдаг иргэн, аж ахуйн нэгжид татварын хөнгөлөлт үзүүлэх асуудлыг судалж санал боловсруулах;

8.2. Чацаргана, жимс, жимсгэний бүтээгдэхүүний стандартыг олон улсын шаардлагад нийцүүлэн шинэчлэх, НҮБ, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын хамтарсан Хууль эрх зүйн хорооноос баталсан зөвлөмж, удирдамж, стандартыг мөрдүүлэх;

8.3. Дотоодын үйлдвэрлэлийг импортын ижил төстэй бараа, бүтээгдэхүүнээс хамгаалах зорилгоор тухайн бүтээгдэхүүний гаалийн тарифыг нэмэгдүүлэх асуудлыг судалж санал боловсруулах;

8.4. Эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэх болон шинжлэх ухааны ололт, технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх чиг үүрэг бүхий жимс, жимсгэний асуудал хариуцсан шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн нэгж байгуулах асуудлыг судалж, санал боловсруулах;

8.5. Чацаргана, жимс, жимсгэнэ тариалсан талбай болон хураасан ургац, боловсруулсан бүтээгдэхүүний тоо хэмжээг статистикийн мэдээнд албан ёсоор оруулах;

8.6. Ашигт малтмалын хайгуул, ашиглалт явуулсан газар нутагт төрөл бүрийн модлог, бутлаг ургамал, түүний дотор чацаргана тариалах замаар байгаль орчны нөхөн сэргээлт хийх санал боловсруулах.

9. “Чацаргана, бусад төрлийн жимс, жимсгэнэ тариалах, хураан авах, боловсруулах технологийг боловсронгуй болгох, мэргэжилтний чадавхийг сайжруулах” зорилтын хүрээнд:

9.1. Чацаргана, жимс, жимсгэний төрөл зүйлийн онцлог шинжчанаарын харьцуулсан судалгаа хийж тухайн бүс нутагт тохирсон шилмэл сортыг сонгон тарьж ургуулах агротехнологи боловсруулж, үйлдвэрлэлд

нэвтрүүлэх;

9.2. Органик гаралтай ургамал хамгааллын болон ургалтыг идэвхжүүлэгч бодис, бордоо болон чацаргана тариалах, хураан авах, хадгалах, боловсруулахад шаардагдах техник, тоног төхөөрөмжийн хангамж, хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах;

9.3. Чацарганы жимснээс шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн гарган авах, хадгалах, хэрэглэх технологи, уг бүтээгдэхүүний биохимийн найрлага, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөнд эрдэм шинжилгээ, клиник судалгаа хийх шинжлэх ухааны төслүүд хэрэгжүүлэх;

9.4. Жимс хураах, хадгалах, үйлдвэрлэлийн аргаар боловсруулах технологийг боловсронгуй болгож, техник, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх;

9.5. Чацарганы тосыг өндөр цэвэршилттэй үйлдвэрлэх, төрөл бүрийн хэрэглээ, зориулалтаар савлах, чацарганы жимс, навч, мөчир, холтосыг бүтээгдэхүүний үйлдвэрлэлд ашиглах туршилт явуулах, шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологи бий болгох;

9.6. Чацаргана, жимс, жимсгэний чиглэлээр ажиллаж байгаа судлаач, мэргэжилтэн, үйлдвэрлэл болон жимс, жимсгэний аж ахуй эрхлэгч, сонирхогчдыг дэмжин дотоод, гадаадын мэргэжлийн сургалтад хамруулах, харилцан туршлага солилцох, тэдгээрийн хамтын ажиллагааг хөгжүүлэх;

9.7. Жимс, жимсгэний аж ахуй эрхлэгч болон үйлдвэрлэгчдэд зориулсан мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх багийг сонгон шалгаруулж үйлдвэрлэгч, тариаланчдыг танхимын болон ажлын байран дээрх сургалтад хамруулах;

9.8. Чацаргана, жимс, жимсгэний чиглэлээр үйлдвэрлэл дээрээ сургалт явуулж байгаа ажил олгогчдод хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас дэмжлэг үзүүлэх.

10. Чацаргана тариалах, боловсруулах үйлдвэр байгуулах, хөгжүүлэх санаачилгыг технологийн удирдлага, санхүү, хөрөнгө оруулалт,



зээлийн бодлогоор дэмжих замаар бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд;

10.1. Шилмэл сортын чацаргана, жимс, жимсгэний суулгац үржүүлэн зах зээлд нийлүүлэх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулж дэмжлэг үзүүлэх, тэдгээрийн бэлтгэсэн суулгацыг худалдан авч жимс, жимсгэнэ тариалах иргэн, аж ахуйн нэгжид хөнгөлттэй нөхцөлөөр нийлүүлэх;

10.2. Жил бүр усалгаатай тариаланг өргөжүүлэх чиглэлээр улсын төсвөөс олгож байгаа санхүүжилтийн 25 хүртэл хувийг чацаргана, жимс, жимсгэний талбайг усжуулахад зарцуулах;

10.3. Хувиараа болон өрхийн, эсхүл нөхөрлөл, хоршооны хэлбэрээр жимс, жимсгэний аж ахуй эрхлэх иргэнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас дэмжлэг үзүүлэх;

10.4. Усалгаатай тариалангийн талбайд хамгаалалтын ойн зурвас хэлбэрээр, худгийн дэргэд болон иргэд хувийн хашаа, талбайд чацарганыг дангаар нь буюу бусад жимс, хүнсний ногоотой зэрэгцүүлэн тариалах хөдөлгөөнийг өрнүүлэх;

10.5. Төмөр зам, автозамын дагуу, Ногоон хэрэм үндэсний хөтөлбөрийн хүрээнд ургуулж байгаа ойн зурваст чацаргана тариулах;

10.6. Байгалийн чацаргана, жимс, жимсгэний нөөцийг тогтоон, аймаг, сум хяналтад авч нөхөн сэргээлт, шигүү ургасан хэсэгт сийрэгжүүлэлт хийх ажил зохион байгуулах;

10.7. Жимс, жимсгэнэ бэлтгэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, борлуулах бүх дамжлагад үйлдвэрлэлийн дэвшилтэт технологи нэвтрүүлж, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангаж ажиллах;

10.8. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг урамшуулан дэмжиж, үндэсний болон олон улсын түвшинд монголын газар зүйн заалттай бүтээгдэхүүнээр бүртгүүлэх арга хэмжээ авах, гадаадын зах зээл, маркетингийн судалгаа хийх;

10.9. Стандартын шаардлагад нийцсэн бага, дунд оврын боловсруулах үйлдвэр болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж экспортлох орчин үеийн техник, технологи бүхий томоохон цогцолбор үйлдвэрийг бүсчлэн байгуулахад Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, гадаадын зээл, тусламжид хамруулах;

10.10. Чацарганы үйлдвэрлэл шинээр эрхлэх, үйлдвэрлэлээ өргөжүүлэхэд нь аж ахуйн нэгж, иргэд урт хугацаатай санхүүгийн эх үүсвэр олох боломжийг бүрдүүлэх, эцсийн бүтээгдэхүүнээ дотоод, гадаадын зах зээлд борлуулах үйл ажиллагаанд төрөөс дэмжлэг үзүүлэх.

11. "Бусад төрлийн жимс, жимсгэнэ тариалахыг дэмжих замаар жимс, жимсгэний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн зах зээлд өрсөлдөх чадварыг хөгжүүлж, импортыг бууруулах" зорилтын хүрээнд:

11.1. Байгалийн жимс, жимсгэнэ, чацарганыг тарималжуулах, нутагшуулах, түүнийг селекцийн эх материал болгон ашиглаж сайжруулах замаар өөрийн орны байгаль цаг уурын нөхцөлд зохицсон арвин ургац бүхий сорт, дээжүүдийг бий болгох;

11.2. Бүс нутгийн уур амьсгалын онцлог, жимс, жимсгэнэ тариалж ирсэн уламжлалд тулгуурлан үхрийн нүд, мойл, улаалзгана, бөөрөлзгөнө, долоогоно, нохойн хошуу, тошлой, нэрс, аньс, гүзээлзгэнэ, тэс, өрөл, алим, давжаа алим, чавга зэрэг жимс, жимсгэнийг нутагшуулан турших, тариалахыг дэмжих;

11.3. Жимс, жимсгэний генефонд байгуулах, манай улсад ургах боломжтой жимс, жимсгэний мод, суулгацыг гадаад орнуудаас оруулан турших, тариалахад дэмжлэг үзүүлэх;

11.4. Хамгаалагдсан хөрсөнд нимбэг, жүрж, алим, чавга, интоор, бөөрөлзгөнө, гүзээлзгэнэ зэрэг ургац арвинтай жимс, жимсгэнэ тариалах, тэдгээрийн төрөл бүрийн сортын суулгац, үрслүүлэг үржүүлэх, судалж турших санаачилгыг бүх талаар дэмжих;

11.5. Органик жимс, жимсгэний тариалалтыг бүх талаар дэмжин Ногоон барааны тэмдэгтийг нэвтрүүлэх, жимст цэцэрлэгийг ашиглан



"Ногоон аялал жуулчлал"-ыг хөгжүүлэх;

11.6. Чацаргана, бусад төрлийн жимс, жимсгэний мод, бутыг төв суурингийн цэцэрлэг, ногоон байгууламжид тариалан цэцэрлэгжүүлэлтэд өргөн ашиглах.

12. "Хөтөлбөрийн ач холбогдлыг нийтэд сурталчлах, дотоодын жимс, жимсгэнэ, түүгээр боловсруулсан бүтээгдэхүүний борлуулалтын сүлжээ бий болгох" зорилтын хүрээнд:

12.1. Жимс, жимсгэний ач холбогдол түүний зохистой хэрэглээ болон үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний ашигт чанарыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлан таниулах;

12.2. "Монгол-Чацаргана" брэнд бүтээгдэхүүнийг бий болгон дотоодын болон олон улсын уулзалт, семинар, хэлэлцүүлэг, эрдэм шинжилгээний бага хурал, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, сонирхогч орнуудад сурталчлан таниулах, хамтарч ажиллах;

12.3. Сургалтын байгууллагыг түшиглэн дотоодын жимс, жимсгэний зохистой хэрэглээг бий болгоход чиглэсэн мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэн хэрэглэгчдийн мэдлэгийг дээшлүүлэх;

12.4. Цэцэрлэг, сургуулийн дотуур байр, эмнэлэг, сувиллын газруудад болон "Үдийн цай" хөтөлбөрийн хүрээнд дотоодын үйлдвэрийн стандарт, чанарын шаардлага хангасан жимс, жимсгэнэ болон тэдгээрийг боловсруулсан бүтээгдэхүүнийг өргөн хэрэглэх;

12.5. Чацаргана, бусад төрлийн жимс, жимсгэнэ тариалах, дахин боловсруулах талаар шинжлэх ухааны байгууллагуудын судалгаа, шинжилгээний үр дүн, иргэд, аж ахуйн нэгжийн туршлага, санал санаачилгыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах, түгээх;

12.6. Жимс, жимсгэнэ болон тэдгээрийг боловсруулсан бүтээгдэхүүний борлуулалтын дотоод, гадаадын сүлжээг бий болгох.

Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат

13. "Чацаргана" хөтөлбөрийг 2 үе шаттайгаар 2016 он хүртэл хэрэгжүүлнэ:

13.1. I үе шат-2010-2012 он

13.1.1. хөтөлбөрийг сурталчлах, чацаргана, бусад жимс, жимсгэний аж ахуй эрхлэх, хөгжүүлэх эрх зүй, эдийн засгийн орчинг сайжруулан, жилд 5 саяас доошгүй суулгац бэлтгэх нөхцөлийг бүрдүүлж тариалсан талбайн хэмжээг 10.0 мянган га хүртэл нэмэгдүүлнэ.

13.1.2. чацаргана хураах ажиллагааг хөнгөөчлөх, жимсийг боловсруулах техник, технологийг боловсронгуй болгож, үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлснээр жимс, жимсгэнэ, түүгээр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний дотоодын хэрэгцээг хангаж маркетингийн сүлжээг бий болгоно.

13.2. II үе шат-2013-2016 он

13.2.1. жимс, жимсгэнэ тариалах чадавхийг бэхжүүлсний үндсэн дээр чацаргана тариалалтыг 20.0 мянга хүртэл га-д хүргэн өндөр технологи бүхий боловсруулах үйлдвэрийг бүсчлэн байгуулж, олон улсын стандартын шаардлагад нийцсэн органик гарал бүхий газар зүйн заалттай, экологийн цэвэр нэрийн бүтээгдэхүүнийг бий болгож, экспортод тогтвортой гаргадаг болно.

13.2.2. чацаргана, жимс, жимсгэнэ тариалах, ургац хураах, боловсруулах үйл ажиллагааг тогтмолжуулж дотоодын хэрэглээ, экспортод гаргах бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлнэ.

Долоо. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт

14. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих үүрэг бүхий Үндэсний зөвлөл ажиллана. Үндэсний зөвлөлийг хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын



гишүүн тэргүүлнэ.

15. Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд холбогдох сайд, дэд сайд, яам, агентлаг, төрийн бус байгууллага, эрдэмтэн, судлаач, үйлдвэрлэгчдийн төлөөлөл оролцсон байх бөгөөд Үндэсний зөвлөлийн дарга томилж, чөлөөлнө.

16. Аймаг, нийслэлд хөтөлбөр хэрэгжүүлэх салбар зөвлөл ажиллах бөгөөд түүнийг тухайн шатны Засаг дарга ахалж, гишүүдэд орон нутгийн төрийн захиргааны болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн төлөөлөл орж ажиллана.

17. Хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөөг Үндэсний зөвлөл болон салбар зөвлөлүүд боловсруулан баталж, хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүр тооцож ажиллана.

18. Хөтөлбөрт заагдсан зарим зорилт, чиг үүрэг, үйл ажиллагааг шялжлэх ухааны болон төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.

19. Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг аймаг, нийслэл нь жил бүрийн 1 дүгээр сард багтаан хүнсний асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад, төрийн захиргааны төв байгууллага нь жил бүрийн I улиралд багтаан Засгийн газарт тайлагнана.

Найм. Хөтөлбөрийн санхүүжилт

20. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг дараахь эх үүсвэрээс бүрдүүлнэ:

20.1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өөрийн хөрөнгө;

20.2. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө;

20.3. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, Тариаланг дэмжих сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Шинжлэх ухаан, технологийн сангаас олгох хөрөнгө;

20.4. Ойжуулах, байгаль орчныг хамгаалах чиглэлийн сан болон уг зориулалтаар улсын төсөвт тусгагдсан хөрөнгө;

20.5. Хандивлагч орон, олон улсын байгууллагын зээл, техникийн болон буцалтгүй тусламж, хандивын хөрөнгө;

20.6. Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн байгаль орчныг нөхөн сэргээхэд зарцуулж байгаа хөрөнгө;

20.7. Бусад эх үүсвэр.

21. Хөтөлбөр хэрэгжүүлэхэд төрөөс үзүүлэх дэмжлэгийг иргэн, аж ахуйн нэгжийн өөрийнх нь хөрөнгө оруулалттай хослуулан хөтөлбөрт заасан үр дүнд хүрэх хариуцлагын тогтолцоог бүрдүүлнэ.

Ес. Хүлээгдэж байгаа үр дүн

22. Чацаргана, бусад жимс, жимсгэнэ тариалах талбай нэмэгдэж боловсруулах үйлдвэр байгуулагдан Монгол Улс 20 мянга хүртэл га талбай бүхий жимст цэцэрлэгтэй болно.

23. Органик гаралтай экологийн цэвэр бүтээгдэхүүний нэр төрөл, хэмжээ өсч жимс, жимсгэний дотоодын хэрэгцээг 30 хувиар хангана.

24. Чацарганы судалгааг гүнзгийрүүлж, бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулан дотоодын хэрэгцээнээс гадна экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг болж хөгжинө.

25. Экологийн нөхөн сэргээлт хийх, мод, суулгац үржүүлэх, хот цэцэрлэгжүүлэлт, ойн аж ахуйн үйл ажиллагаа өргөжинө.

26. Байгалийн чацаргана болон бусад жимс, жимсгэний талбайг хамгаалалтад аван нөхөн сэргээж, байгалийн жимс, жимсгэнийг зохистой ашиглах тогтолцоо бүрдэнэ.

27. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад жимсний аж ахуй,

боловсруулах үйлдвэрлэлээр дагнан ажиллах 20 мянгаас доошгүй ажлын байр бий болгож, жимс, жимсгэний аж ахуй нь газар тариалангийн бие даасан дэд салбар болон хөгжинө.

28. Таримал жимс, жимсгэний нэр төрөл нэмэгдсэнээр хүн ам аюулгүй, экологийн цэвэр жимс, жимсгэнийг хүнсэндээ тогтвортой хэрэглэдэг болно.

Арав. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

29. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг дараахь шалгуур үзүүлэлтээр хэмжинэ:

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Одоогийн түвшин	Хүрэх түвшин	
				I үе шат	II үе шат
1	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор баталсан эрх зүйн баримт бичиг, түүний хэрэгжилт	үйл ажиллагааны хэрэгжилтээр			
2	Чацаргана тариалсан талбай	га	960	10000	20000
3	Хураан авсан ургац	тонн	500	3500	7000
4	Бэлтгэсэн суулгац	мянган ширхэг	300	5000	6000
5	Дотоодын үйлдвэрлэлийн жимс, жимсгэний хангамж	хувь	0.5	10	30



6	Шинээр бий болох ажлын байрны тоо	хүн	1000	10000	20000
7	Элсний нүүдлээс хамгаалах, байгаль нөхөн сэргээх зориулалтаар чацарганыг ашигласан байдал	га	60	1000	3000
8	Экспортлосон бүтээгдэхүүн	үйл ажиллагааны хэрэгжилтээр			
9	Байгалийн чацаргана, жимс жимсгэний талбай сэргээгдсэн байдал	үйл ажиллагааны хэрэгжилтээр			
10	Шинжлэх ухаан, биотехнологийн ололтыг үйлдвэрлэлд ашигласан байдал	үйл ажиллагааны хэрэгжилтээр			

Хаяг:

"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн редакци


Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот

И-мэйл: tariin_medeelal@parliament.mn

Утас: 262420, 329612

Хэвлэлийн хуудас 2.75

Индекс: 14003



Улсын Их Хурлын Төмөр газрын хэвлэх хэсэгт хэвлэв.
Утас 329487